



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН 2024

Агуулга

01

Өмнөтгөл

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Банкны тухай
- Тайлангийн тухай

02

Байгаль орчин

- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь
- Тогтвортой санхүүжилт

03

Нийгэм

- Олон талт байдал ба оролцоо
- Ажлын тав тухтай нөхцөл ба хөгжил
- Нийгмийн оролцоо

04

Засаглал

- Компанийн засаглал
- Ёс зүй ба комплайнс
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

05

Хавсралт

- SASB индекс
- GRI индекс
- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж



Та бүхэндээ банкныхаа 2024 оны Тогтвортой хөгжлийн тайлан танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнөөдөр банк, санхүүгийн байгууллагууд нь зөвхөн санхүүгийн зуучлагч байхаас гадна уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдал зэрэг суурь сорилтуудын үед эдийн засгийн зөв шилжилт, хариуцлагатай өсөлтийг дэмжих чухал үүрэг хүлээж байна. Иймээс тогтвортой хөгжил бол бидний хувьд сайн дурын санаачилга бус, харин урт хугацааны тогтвортой байдал, үндэсний хөгжил дэвшлийг тодорхойлох стратегийн асуудал юм.

2024 он нь ХХБ-ны хувьд энэ ойлголтоо бодит алхмуудаар бататгасан чухал жил болж өнгөрлөө. Бид "Ногоон банк" болох урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд богино хугацааны үр дүнгээс илүүтэйгээр банкныхаа ирээдүйн тогтвортой өсөлтийг хангах суурь бүтэц, тогтолцоо, чадавх болоод стратегийн түншлэлээ бэхжүүлэхэд голлон анхаарч ажиллаа.

Тухайлбал, Уур амьсгалын ногоон сангийн ("GCF") бэлэн байдлын хоёр төслийг хэрэгжүүлэн, олон улсын хөрөнгө оруулагчдад зориулсан Монгол Улсын анхны "Ногоон болон нийгмийн бонд"-ыг амжилттай гаргалаа. Мөн түүнчлэн АНУ-ын Засгийн газрын дэргэдэх Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпорацаас ("DFC") урт хугацааны санхүүжилт татсан маань Монголын банк, санхүүгийн салбарт анхдагч болоод зогсохгүй, ХХБ нь олон улсын түвшний итгэлцэл, стандартын шаардлагыг хангасан банк гэдгийг дахин бататгасан чухал үйл явдал болов.

Цаашлаад, бид Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ("GIZ"), Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо ("ТоС Холбоо")

зэрэг дотоодын болон олон улсын байгууллагуудтай түншлэлээ өргөжүүлж, тогтвортой санхүүжилтийн экосистемийг бэхжүүлэхэд төвлөрснөөр манай зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн чиглэлд бодит үнэ цэн, үр өгөөжийг бий болгож байна.

Ирж буй 2025 он бидний хувьд энэхүү эрчээ хадгалж, үр нөлөөгөө тэлэх чухал жил байх бөгөөд бид өнөөг хүртэлх амжилтууддаа тулгуурлан эдийн засгийн голлох салбаруудын ногоон шилжилтийг хурдасгах шинэ шатанд шилжиж байна. Цаашид ХХБ нь Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нүүрстөрөгчийн хэмжээг бууруулсан, дижитал хөгжилд тулгуурласан эдийн засаг рүү хийх шилжилтийг зөвхөн санхүүжилтээр бус, мөн баримталж буй стандарт, хөгжүүлж буй түншлэл, хэрэгжилтээрээ дамжуулан дэмжиж, манлайлах болно.

Бидний энэхүү аялалд хамтран зүтгэж буй нийт ажилтнууд, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг харилцагчид, түнш байгууллагууд болон хөрөнгө оруулагчдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний итгэл, оролцоо, хамтын ажиллагаа бидний ахиц дэвшлийн үндэс билээ. Бид тогтвортой хөгжлийг зөвхөн үүрэг хариуцлага гэж бус, харин Монгол Улсын урт хугацааны хөгжил, бодит дэвшлийг хурдасгах чухал хөшүүрэг гэж үздэг. Хамтын хүчин чармайлт, нэгдмэл зорилгын үндсэн дээр бид илүү тэсвэртэй, хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг хамтдаа бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

O.ОРХОН

Гүйцэтгэх захирал

Банкны тухай

Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь 1990 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын банк санхүүгийн салбарын манлайлагч байгууллага юм. Монгол Улсын үүган банк болох ХХБ нь олон улсын стандартад нийцсэн 130 гаруй нэр төрлийн банкны бүтээгдэхүүн болон харилцагчдад ээлтэй банкны үйлчилгээг санал болгож байна. ХХБ нь Монголын санхүүгийн салбарын томоохон тоглогч, шинийг санаачлагч банк юм.

Уриа



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Тогтвортой хөгжлийн тодорхойлолт болох ирээдүй хойч үеийн хэрэгцээг бууруулахгүйгээр дэлхийн өнөөгийн хүн амын хэрэгцээг хангах цогц үйл явцыг банк, харилцагч, түнш болон улс орон хамтдаа дэмжиж, нэг зорилгын дор нэгдэж ажиллахыг үриалсан утгатай.

Эрхэм зорилго



Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.

Алсын хараа



Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.



TDBank

Customer centric — *Customer*

Recognition

Excellence

Accessible &

cor

SME

BIT

БҮТЭЭГЧ

Бидний харилцаа

Үнэлэмжтэй

Төгс төгөлдөр

Эгнэгт ээлтэй

Эвсэг баг

Гүйцэтгэл төгс

Чин хүндлэл



Нийт актив

15 их наяд



Үйл ажиллагааны орлого

648.07 тэрбум



Цэвэр ашиг

308.08 тэрбум



Нийт ажилтан

2,261 ажилтан



Байгууллагад олгосон зээлийн хэмжээгээр зах зээлийн

30%



МУ-ын ТОП-100 ААН-ээс банкны урт хугацааны харилцагч

94 байгууллага




Дэлхийн корреспондент харилцаатай банк, санхүүгийн байгууллага

292 гаруй



Ностро данс

85 данс



Нийгмийн зээлийн багц

1.7 их наяд



Ногоон зээлийн багц

113.5 тэрбум

Стратеги

Урт хугацааны стратеги



ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ БАНК

Харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, борлуулах, харилцагчаа халамжлах, тогтоон барих, оновчтой сувгаар харилцагч бүрд хүрч ажиллан үнэ цэнийг хүргэнэ.



ОЛОН УЛСЫН (БӨГӨӨД НОГООН) БАНК

Бизнес, үйл ажиллагааны загварыг олон улсын жишиг стандартад нийцүүлж, мэргэжлийн, зөв зохион байгуулалттай, оновчтой шийдлээр харилцагчид, ажилтнууд, түншүүд, хамтрагч байгууллагуудад найдвартай үйлчилгээг хүргэж, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, олон улсад үйл ажиллагаагаа тэлнэ.



ПЛАТФОРМ БАНК

Финтек, дижитал шийдэл хөгжүүлэгч компаниудтай нээлттэй хамтран ажиллаж, харилцагчдын үнэ цэний гинжин хэлхээг бий болгосон дижитал шийдлүүдийг нэвтрүүлж, банк, харилцагчид, түнш байгууллагуудын нэгдсэн эко системтэй болно.

Дунд хугацааны стратеги



Санхүү
4 зорилтууд



Харилцагч
6 зорилтууд



Дотоод процесс
8 зорилтууд



Сургалт ба хөгжил
6 зорилтууд

Банк нь алсын хараа, эрхэм зорилго болон урт хугацааны стратегиудтай уялдуулж дээрх 4 чиглэлийн хүрээнд дунд хугацааны 24 зорилтуудыг тодорхойлсон ба уг зорилтуудын дагуу ажиллаж байна.

Тайлангийн тухай

"Тогтвортой хөгжлийн тайлан 2024" нь Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх санхүүгийн жилийн үйл ажиллагааг хамарсан бөгөөд тогтвортой санхүү, байгаль орчин, нийгэм ба засаглал (ESG)-ын хүрээнд банкны хийж гүйцэтгэсэн ажлуудыг тайлагнасан. Тайлан нь 9 сэдвийн хүрээнд, тухайн асуудалтай холбоотой бидний оролцоо, зорилго, стратеги, бизнес болон нийгэмд хамааралтай байдал болон өнөөг хүртэлх ахиц дэвшлийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Sustainability Accounting Standards Board (SASB), БОНЗ, тогтвортой хөгжлийн тайлагналын удирдамж болон Global Reporting Initiative (GRI) зэрэг тайлагналын тогтолцоо, стандартуудад уялдуулан боловсруулагдсан болно.



Тогтвортой хөгжил

- Шилдэг Байгууллагын Банк
- Жендэрийн Манлай Байгууллага

4 QUALITY EDUCATION



₮ 93.6 ТЭРБУМ

ХХБ-ны боловсролын салбарт олгосон зээлийн багц

STEAMEX 2024

Тус хөтөлбөрт оролцох 100 багшийн төлбөр

ХЯЗГААРГҮЙ МӨРӨӨДӨЛ

5 GENDER EQUALITY



₮ 94.5 ТЭРБУМ

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл

87%

Нийт эмэгтэй ажилтнууд

LADY'S LEADERSHIP

Хөтөлбөр

8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH



₮ 6.3 ИХ НАЯД

ХХБ-ны нийт зээлийн багц

ЗӨГИЙН ҮҮР

Хөтөлбөр

SFME

Төсөл

120 САЯ ам.доллар

U.S International Development Finance Corporation

13 CLIMATE ACTION



**НОГООН БОЛОН
НИЙГМИЙН БОНД**

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРОО

**УАНС-Н САНХҮҮЖИЛТТАЙ 2 БЭЛЭН
БАЙДЛЫН ТӨСӨЛ**



БАЙГАЛЬ ОРЧИН


- БИДНИЙ ОРОЛЦОО
- ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

114,485 тн CO₂e

ХХБ нь Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээс хойш санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд **114,485 тонн CO₂e** хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.



ХХБ-ны санхүүжүүлсэн ХХЯ-ын бууралт бий болгох төслүүдийн ангилал



61% Эрчим хүч үйлдвэрлэл дэх түлшний шилжилт

22% Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж

15% Тогтвортой ус ба хог хаягдал


2% Бохирдол багатай эрчим хүчний үйлдвэрлэл

ХХБ нь өөрийн үйл ажиллагаанаас



759.1 кг

Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулсан



6.4 кг

Ашигласан баттерейг дахин боловсруулсан

Бидний оролцоо

Банк нь "Ногоон банк" болох урт хугацааны стратегийн дагуу нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын саармаг байууллага болох зорилгыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ногоон бизнес загварыг томоохон аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд нэвтрүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хүргэж, хамтын үнэ цэний бүтээхэд чиглэн ажиллаж байна.

2050



Банкны дотоод болон зээлийн үйл ажиллагаанаас ялгаруулах нүүрсстөрөгчийн цэвэр ялгарлыг тэг болгоно.

2030



\$2 ТЭРБУМ

- \$1 тэрбум хүртэлх ногоон санхүүжилтийг олгох
- \$1 тэрбум хүртэлх нийгмийн санхүүжилтийг олгох

2025




СТОУС S1 ба S2 стандартуудыг нэвтрүүлэх

2020



Тогтвортой, ногоон банк болох суурийг тавьж зорилтоо дэвшүүлнэ.





Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор манай байгууллага 2024 оны үйл ажиллагаандаа "Уур амьсгалын үйл ажиллагаа ба тогтвортой санхүүжилт" болон "Уур амьсгалын талаарх ойлголт нэмэгдүүлэх ба чадавх бэхжүүлэх" гэсэн хоёр үндсэн материал сэдвийг тодорхойлон ажилласан болно. Эдгээр сэдвүүд нь байгууллагын бодит нөлөөлөл болон оролцогч талуудын анхаарал хандуулдаг чухал чиглэлүүд юм.

УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Бид ногоон шилжилтийг дэмжих үүднээс тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлж, олон улсаас ногоон бонд, үрт хугацаат санхүүжилтийг амжилттай татсанаар харилцагчдынхаа ногоон шилжилтэд хувь нэмрээ оруулж чадлаа. Мөн Тэрбум мод хөдөлгөөн, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

УУР АМЬСГАЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ БА ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

Уур амьсгалын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд мэдлэг, хамтын ойлголт зайлшгүй чухал гэж үзэн манай байгууллага олон нийтийн оролцоо, мэдээлэл түгээхэд анхаарал хандуулан ажиллав. Ингэхдээ COP29 болон World Economic Forum зэрэг олон улсын чуулга уулзалтад панелистаар оролцож, дотоодын их дээд сургуультай хамтран судалгаа, техникийн туслалцаа зэргээр чадавх бэхжүүлэн ажиллаж олон нийтийн мэдлэгийг дээшлүүллээ.



УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

ХХБ нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөрс, агаар, усны бохирдлыг үүсгэхгүй, эрчим хүчний эх үүсвэр, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, өв соёл, ахуй уламжлалаа эрхэмлэсэн ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг дэмжих зорилгоор давуу эрх олгох бодлого баримтлан ажилладаг.

Дотоод үйл ажиллагаа

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022	2023	2024
Нийт эрчим хүчний хэрэглээ	Мега Втц'000	4,522	↓ 4,328	↑ 4,724
Өөрчлөлт			4%	9%
Нийт эрчим хүчний хэрэглээ	м³/л	5,190	↑ 5,689	↑ 6,337
Өөрчлөлт			10%	11%
Нийт эрчим хүчний хэрэглээ	тонн	304	↓ 192	↑ 201
Өөрчлөлт			37%	5%

Ногоон цаг

Өдөр бүр 1 цаг ногоон цаг. Гэрлээ унтрааж эрчим хүчээ хэмнэх аян.

Ногоон оффис

ХХБ-ны бүх салбар, нэгж, газар хэлтэст өдөр тутмын үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй болгох, үйл ажиллагаанаас үүдэн бий болж буй сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж өгөх, гарын авлагаар хангах зорилготой Ногоон Оффисын зөвлөмжийг 2024 онд боловсруулан гаргасан ба 2025 оноос зөвлөмжийг дагаж мөрдөн тайлагнаж эхлэх юм.

Дахин боловсруулалт

759кг хуванцар хог хаягдал. Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэв. Өмнөх оноос 639%-р илүү үзүүлэлт юм.

Лайт салбар

Банкны салбар, нэгжийнхээ тоог "Lite" буюу цаасгүй, цахим технологид суурилсан ажилтны оролцоогүй, харилцагч өөрөө өөртөө үйлчлэх автоматажсан салбаруудаар нэмж, банкны үйлчилгээг харилцагчид илүү хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд дэвшилт гарган ажиллалаа.

Дахин боловсруулалт

6.4кг ашигласан баттерей. Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэв. Өмнөх оноос 2 дахин их үзүүлэлт юм.

Тэрбум мод

ХХБ нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллаж нийт 257,580 ширхэг мод буюу 8.42 хувьтай тэнцэх модыг тарьж үргүүллээ. 1,181.65 тонн CO2 хүлэмжийн хийн шингээлт

Тогтвортой санхүүжилтийн хүрээ

ХХБ нь 2021 оны 3-р сард Монголдоо анхлан Тогтвортой санхүүжилтийн хүрээ (Sustainability Framework) баримт бичгийг боловсруулан гаргасан. Энэхүү баримт бичигт банкны ногоон болон нийгмийн зээлийн шалгуурыг нарийвчлан тодорхойлон заасан юм. Энэхүү хүрээ нь олон улсын стандартын нийцэлийг хангах үүднээс хөндлөнгийн үнэлгээг (Second-party Opinion) амжилттай гаргуулсан Монголдоо анхдагч байгууллага болсон билээ (Хөндлөнгийн үнэлгээг Moody's -ийн хараат компани болох V.E /Vigeo Eiris/-ээр гаргуулсан).

Ногоон зээлийн ангилал



Сэргээгдэх эрчим хүч



Бохирдол багатай эрчим хүч



Цэвэр тээвэр



Тогтвортой ус ба хог хаягдал



Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой ба биологийн төрөл зүйл



Ногоон барилга



Эрчим хүчний хэмнэлт

Нийгмийн шинж чанартай зээлийн ангилал




Орлогод нийцсэн дэд бүтэц




Орлогод нийцсэн орон сууц



Нэн чухал үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх



ЖДҮ болон бичил аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэх



120Сая ам.доллар

40%

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл

30%

Бизнесийн болон иргэдийн ногоон зээл

30%

ОУСК-ийн тодорхойлсон бичил, ЖДҮ сегментийн харилцагчдын санхүүжилт

ХХБ нь АНУ-ын Засгийн газрын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорацтай урт хугацааны санхүүжилтийн гэрээг 2024 оны 10-р сарын 24-ний өдөр үзэглэлээ.

Энэхүү гэрээг үзэглэснээр Монгол улсын банк санхүүгийн байгууллага нь АНУ-ын ХСК-аас шууд санхүүжилт босгосон анхны тохиолдол болж байна. Тус санхүүжилтээр Худалдаа, хөгжлийн банк нь Монгол Улс дахь бичил ба жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд зарцуулах замаар МУ-ын тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх том алхам болох юм.



50Сая ам.доллар

80%

Ногоон зээл

20%

Нийгмийн зээл

Монгол Улсаас анх удаа Олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан Нийгмийн болон Ногоон бондыг хаалттай хэлбэрээр Австри Улсын Венийн Хөрөнгийн Бирж дээр гаргалаа.

Энэ нь 2015 онд ХХБ-ны гаргасан бондоос хойших анхны хувийн хэвшлийн гаргаж буй таван жилийн буюу урт хугацаат бонд юм. Тус бондыг гаргаснаар Дэлхийн ТОП аравт багтдаг Ассет Менежмент Компаниас хөрөнгө оруулалт татсан Монголын анхны хувийн хэвшлийн компани ХХБ болж байна. Мөн хөрөнгө оруулалтын Bloomberg терминал дээр бүртгэлтэй Монголын анхны Ногоон болон Нийгмийн бонд юм.

Байгууллагад зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

/2024.12.31-ны байдлаар/

ХХБ-ны ногоон зээлийн үлдэгдэл, ангиллаар


Сэргээгдэх эрчим хүч	3.74%
Бохирдол багатай эрчим хүч	0.04%
Эрчим хүчний хэмнэлт	74.43%
Ногоон барилга	2.47%
Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	0.15%
Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	2.17%
Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жүүлчлал	2.96%
Карбон бага тээвэр	14.04%

Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд


ХХБ-ны санхүүжүүлсэн ХХЯ-ын бууралт бий болгох төслүүдийн ангилал

Тогтвортой ус	0,36%
Бохирдол багатай эрчим хүчний үйлдвэрлэл	2,35%
Тогтвортой хог хаягдал	14,35%
Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж	21,78%
Эрчим хүч үйлдвэрлэл дэх түлшний шилжилт	61,16%

Банкны бизнесийн ногоон зээл олголт өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа ба санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд **114,485тонн CO2e** хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.



- Бизнесийн ногоон зээл
- Зээлийн батлан даалтын сантай бизнесийн ногоон зээл
- Ногоон аккредитив баталгаа
- Бизнесийн ногоон зээлийн эрх



- Онлайн хэрэглээний зээл
- Эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууцны зээл
- Хэрэглээний ногоон зээл
- Цахим ногоон зээл
- Эко автомашины зээл
- Ногоон орон сууцны зээл

УУР АМЬСГАЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ
НЭМЭГДҮҮЛЭХ БА ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

50-250 сая \$ санхүүжилтийн эрх бүхий

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

200,680\$

"МОНГОЛ УЛС ДАХЬ БҮС НУТГИЙН НОГООН ДЭД
БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ" БЭЛЭН БАЙДЛЫН ТӨСӨЛ

291,772\$

"МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ БОЛОН НОГООН
САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ"
БЭЛЭН БАЙДЛЫН ТӨСӨЛ

Бүс нутгийн ногоон хөгжлийг бий болгоход төрийн, дотоод болон олон улсын хувийн хэвшлийн хамтарсан буюу холимог санхүүжилтийн механизмын хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын хот төлөвлөлт, дэд бүтцийг уур амьсгалд тэсвэртэй хөгжүүлэхэд шаардлагатай байгаль орчин, нийгэмд илүү ээлтэй урт хугацаандаа үр өгөөжтэй, тогтвортой ногоон төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх ногоон технологиуд, мөн төслийн санхүүжилтийн схем болон хөнгөлөлтийн механизмыг нарийвчлан тодорхойлох. "Ханбогд сумын ногоон хөгжлийг цогцлоох" төслийн саналын баримт бичгийг боловсруулах.

ХХБ нь ТоС холбоотой хамтран УАНС-ийн буцалтгүй тусламжаар 2022 оноос эхлэн 2 жилийн хугацаанд "Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр" төслийг амжилттай хэрэгжүүлэв.

Төслийн зорилго: Тогтвортой болон ногоон санхүүжилттэй төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн салбар болон холбогдох оролцогч талуудын чадавхыг дээшлүүлэх, системийн түвшинд уур амьсгалын санхүүжилтийн зарчмуудыг хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх.



“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ БОЛОН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ НЭМЭГ ДҮҮЛЭХ” БЭЛЭН БАЙДЛЫНТӨСЛИЙН ҮР ДҮН

- Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдлийг үнэлэх, удирдах аргачлалыг батлуулав.
- Монгол улсын санхүүгийн байгууллагуудын жендэрийн тэнцвэртэй, гэр бүлд ээлтэй үйл ажиллагааны суурь судалгаа; банк санхүүгийн байгууллагуудад зориулсан Жендерийн бодлогын зааврыг боловсруулав.
- “Ногоон зээлийн бодлогын хөшүүрэг” зөвлөмж, тайлан.
- Монголын Тогтвортой дижитал санхүүжилтийн хэрэгцээний суурь судалгаа, замын зургыг олон улсын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Beijing Trans FinTech Ltd.-р хийлгүүлэв.
- Таксаномийн голлох 3 салбар ангиллуудын ногоон зээлийн удирдамж, гарын авлагыг боловсруулав.
- ESG Pedia-тай хамтран боловсруулсан Ногоон, тогтвортой төсөл, зориулалтыг Таксономийн ангиллын дагуу таних, тодорхойлох анхан шатны хялбаршуулсан аргачлал бүхий “ТХЗ-уудын Таксономийн цахим хайлт” хэрэгсэл.
- Ногоон төсөл хөтөлбөрийн хянах зорилгоор хүлэмжийн хийн ялгаралыг тооцоолох хэрэглүүр.
- ХБНГУ-ын Франкфурт хотод “Монголын банк, банк бус санхүүгийн салбарын ногоон санхүүжилтийн чадавхыг сайжруулах, туршлага судлах” аялалыг амжилттай зохион байгуулав.
- Төслийн хэрэгжилтийн хугацаанд нийт 6 удаагийн воркшоп арга хэмжээг зохион байгуулж, 617 харилцагчийг хамруулан амжилттай гүйцэтгэлээ.

Бидний оролцоо болон чадавх бэхжүүлэлт



Дэлхийн Эдийн Засгийн Форумын "Шинэ Манлайлагчдын чуулга уулзалт 2024"



НҮБ-ын Суурь Конвенцын Талуудын 29 дүгээр бага хурал (COP29)



Монголын Тогтвортой Санхүүгийн Форум 2024



Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ийн өдөр



НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа Улаанбаатар хот дахь агаарын бохирдлын асуудлыг сэргээгдэх эрчим хүчинд суурилсан шийдлээр багасгаж, олон нийтийн эрүүл мэнд, аж амьдралд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор гэр хороолол дахь өрхүүдийн нүүрсний хэрэглээг халж, нарны халаалтын системд шилжихэд дэмжлэг үзүүлэх "If Only I Could Go Solar" хамтын санхүүжилт босгох аянд нэгдэн 1 өрхийг иж бүрэн нарны халаалтын системээр хангахад хандивлав.



Банкны үйл ажиллагаанд ашиглах боломжгүй техникийн хог хаягдлыг Дүдү хүүхдийн музейд хандивлав. Тухайн музей нь тус хог хаягдлыг шинжлэх ухаанд сонирхолтой бага насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах Воркшопд ашиглах, ашиглаж дууссаны дараа байгальд ээлтэйгээр хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт хандивлахаар тохиролцсон. Ингэснээр бид Ногоон банк болох зорилгын хүрээнд шинжлэх ухаанд сонирхолтой хүүхэд багачуудыг бодитоор дэмжин ажиллалаа.



Шотланд улсын Эдинбургын их сургуулийн Уур амьсгалын санхүүжилт хөтөлбөрийн хүрээнд магистрийн төгсөх оюутнуудтай 2024-2025 оны хичээлийн жилд "Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход ашиглагдах ногоон санхүүжилтийн загварууд" гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд хамтран "Тогтвортой хөдөө аж ахуй ба ногоон санхүүжилт" сэдэвтэй олон улсын жишигтэй харьцуулсан судалгаа хийн ажиллаа.



НИЙГЭМ


- Олон талт байдал ба оролцоо
- Нийгмийн оролцоо



33% эрэгтэй



66% эмэгтэй




2,261

Ажилтан цалин, урамшууллаа нэмэгдүүлэн ажиллав.



401

Шинэ ажилтан томилогдов.



560+

Ажилтан албан тушаал дэвшив.



1.7 их наяд

Нийгмийн зээлийн багц



94.5 тэрбум

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл



**ЖЕҢЭРИЙН МАНЛАЙ
БАЙГУУЛЛАГА**



34

төрлийн үйл ажиллагааг дэмжин ажиллалаа



100%

Гомдол шийдвэрлэв.

Бидний нийгмийн нөлөөлөл нь дотоод болон гадаад гэсэн 2 ангилалд хуваагдаж байгаа ба ингэхдээ дотоод буюу хүний нөөц болох 2,261 талентууд хамаарч байгаа бол гадаад буюу бидний хариллагчид, олон нийт мөн бүлэгүүд харьяалагдаж байна.


Олон талт байдал ба тэгш оролцоо


	Хүйсээр		Байршилаар		Насны бүлгээр			Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	Улаанбаатар	Орон нутаг	26-аас доош	26-35	36-аас дээш	
Нийт ажилтан	752	1,509	1,842	174	640	1,129	492	2,261
Шинэ ажилтан	210	398	575	33	368	206	34	608
Гэрээт ажилтан	1	10	8	3			11	11



Банк нь "Хөдөлмөрийн тухай хууль"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг ба тус хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууддаа зориулан ээлжийн амралтын нэмэгдэл өдрүүд, ажлын богиносгосон цаг зэргээр дэмжлэг үзүүлж ажилладаг. **Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны нийт ажилтны тоонд эзлэх хувь 0.8%** байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (ХХДХ)-тэй харьцуулбал






LADY'S LEADERSHIP ХӨТӨЛБӨР

Нярайн чөлөөнөөс эргэн ажилдаа томилогдсон ажилтнуудын карьер хөгжлийг дэмжих, тэдний манлайллын чадварыг нэмэгдүүлэхэд зорилгоор 3 удаагийн модуль сургалтын хөтөлбөр боловсруулж, амжилттай хэрэгжүүлэв.


Тус хөтөлбөрийн агуулгаар:

- Self esteem
- Жендэрийн мэдрэмжтэй манлайлал
- Эмэгтэйчүүдийн манлайлал



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫГ ДЭМЖИХ МЕНТОР-2024 ХӨТӨЛБӨР

Эмэгтэй ажилтнуудын манлайллыг дэмжих, карьерын хөгжлийг нь урамшуулан дэмжих зорилгоор туршлагатай ментор томилж, нэг сарын хугацаанд менторын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд оролцогчдын үр чадварыг хөгжүүлэх, хамтдаа суралцах, өсөж дэвших боломжийг бүрдүүлэв.




TDB FLEXIBLE MOM ХӨТӨЛБӨР

Нярайн болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудын нийгмийн сайн сайхан байдлыг дэмжиж, тасралтгүй хөгжүүлэх, нэмэлт орлоготой болох боломжийг олгох зорилгоор банкны "Харилцагчийн мэдээллийн хэлтэс"-т зайнаас ажиллууллаа. Тус хөтөлбөрийн сэтгэл ханамжийн үр дүн өндөр байгаа тул жил бүр хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.




ДАСАН ЗОХИЦОХ ХӨТӨЛБӨР

Шинээр томилогдон ажиллаж буй ажилтнуудаа халамжлах, сургаж хөгжүүлэх зорилгоор дасан зохицох хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөрт тухайн ажилтны удирдлагын арга барил, хамт олны соёл, эерэг үүр амьсгал шууд нөлөөтэй бөгөөд тогтмол судалгаа авч сайжруулан ажиллалаа.



ЖЕНДЭРИЙН БАГШ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР

Жендерийн сургагч багш бэлтгэх, сургах, дадлаажуулах хөтөлбөрийг дотооддоо амжилттай хэрэгжүүлэв. Хөтөлбөрт оролцох хүсэлтэй олон ажилтнаас сонгон шалгаруулалт хийж, 3 ажилтан багшлах эрхийн сертификат авсан нь онцлох үр дүн байлаа. Тэдгээр сургагч багш нар банканд шинээр томилогдсон ажилтнуудад зориулсан "Шинэ ажилтны чиглүүлэх сургалт"-ын хүрээнд "Жендерийн эрх тэгш байдлын бодлого" сэдвээр сургалт орж, байгууллагын жендерийн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.



ЦАЛИНТАЙ ДАДЛАГАЖИХ ХӨТӨЛБӨР /ERASMUS/

СЭЗИС-тай хамтран банкны газар нэгжүүд дээр цалинтай болон цалингүй дадлагын хөтөлбөрийг амжилттай зохион байгууллаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд оюутнуудад мэргэжлийн орчинд бодит туршлага хуримтлуулж, үр чадвараа хөгжүүлэх боломжийг олгов. Хөтөлбөрт амжилттай оролцсон дадлагын оюутнууд шууд ажлын байраар хангагдан, хамт олны бүрэлдэхүүнд ажиллаж байна.



1.

"Хязгааргүй мөрөөдөл" төслөө хоёр дах удаагаа аутизмтай хүүхдүүдэд зориуллаа. Ингэхдээ "Аутизм Анд ТББ"-ын дэргэдэх "Анүүлэн аз жаргал" цэцэрлэгийн сургалтын анги танхимыг нь бүрэн тохижуулж өглөө. Тус сургалтын өрөөг байгуулснаар хичээл заах орчныг сайжруулах, хүүхэд багачуудын нийгмийн харилцаанд орох орчныг илүү тав тухтай болгоход хэрэгтэй юм. Бид цаашид ч Монгол Улсын хүүхэд бүр тэгш боломжоор хангагдаж, тэгш орчинд сурч боловсрох боломжтой байхын төлөөх ажлуудыг дэмжин ажиллах болно.



2.

Дэлхийн Аутизмын сарыг тохиолдуулан "Хязгааргүй мөрөөдөл" төслөө аутизмтай онцгой хүүхдүүдэд зориулан хэрэгжүүлжээ. Ингэхдээ Аутизм ба Бусад Онцгой Хүүхдүүдийн Академид "хүүхдүүд дүрд орж тоглох сургалтын өрөөг иж бүрэн тохижуулж" өгсөн. Тус сургалтын өрөөг байгуулснаар хүүхдүүд хэл яриа, харилцааны хувьд хөгжиж, нийгмийн харилцаанд ороход нь хэрэгтэй юм.



3.

Дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан Налайх дүүргийн Голомт цогцолбор сургуулийн номын санг тохижуулж, номоор баяжуулж өглөө. Ийнхүү Хязгааргүй мөрөөдөл төсөл нийт 58 сургууль цэцэрлэгийн 200 мянга гаруй хүүхэд, 10000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчдийн боловсролд оюуны хөрөнгө оруулалт хийгээд байна. Бид цаашид ч нийгмийн хариуцлагын хүрээнд уг төслөөр дамжуулж, Монголын хойч ирээдүй болсон хүүхэд, залуусыг сурч боловсрох боломжоор дэмжин ажиллах болно.



4.

ХХБ-ны ууган салбаруудын нэг Эрдэнэт салбарын үүсгэн байгуулагдсаны түүхт 25 жилийн ой энэ онд тохиож байна. ХХБанкны Эрдэнэт салбар анх 1999 онд Орхон аймгийн Баян-Өндөр сум буюу Эрдэнэт хотноо Чандмань төвд 807-р салбар нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан түүхтэй. Ойн баяраараа ХХБ эх үрсийн эрүүл мэндийг дэмжих, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор "Орхон аймаг дахь Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв"-д нярайн шарлагын аппарат бэлэглэлээ.



ВЕТ ON BABY ТӨСӨЛ

АНУ-ын "ABC" телевизийн уран бүтээл Bet on Baby шоу нэвтрүүлгийг албан ёсны эрхтэйгээр Монголд анх удаа NTV телевиз хүргэсэн. ХХБ МААМУУ хүүхдийн хадгаламжаар дамжуулан олон нийтэд санхүүгийн боловсрол олгох чиглэлд хамтран ажиллаа.



МААМУУ ХҮҮХДИЙН КОНТЕНТ

Бага насны хүүхдүүдийн гэгээн хүсэл мөрөөдлийг сонсож, Сантатай уулзах хүсэл биелүүлэх болон хүүхдүүдээр дамжуулан санхүүгийн боловсрол олгох зорилготой Маамуу хүүхдийн контентыг бэлтгэн социал медиагаар олон нийтэд хүргэв.



STEAMEX

Монголд анх удаа олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох STEAMEX 2024 зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний үеэр бага ангийн болон байгалийн ухааны багш нарыг чадавхжуулах 100% практик туршилт, бүтээлд суурилсан хөтөлбөрт 21 аймаг бүрээс оролцох 100 багшийн төлбөрийг төллөө.



ДҮДҮ МУЗЕЙ

Банкны үйл ажиллагаанд ашиглах боломжгүй техникийн хог хаягдлыг шууд хогийн цэг дээр устгахгүйгээр банктай хамтран ажилладаг Дүдү хүүхдийн музейд хандивллаа. Тухайн музей нь тус хог хаягдлыг шинжлэх ухаанд сонирхолтой бага настай хүүхдүүдийн дунд зохион байгуулах Workshop-доо ашиглах, ашиглаж дууссаны дараа байгальд ээлтэйгээр хог хаягдал дахин боловсруулдаг үйлдвэрт хандивлахаар тохиролцсон. Ингэснээр банк НОГООН банк болох зорилгын хүрээнд болон шинжлэх ухаанд дуртай хүүхэд багачуудыг бодитоор дэмжих ажил боллоо.




“CSR AWARDS 2024”

Монгол дахь Америкийн Худалдааны танхим AmCham Mongolia-с зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ “CSR AWARDS 2024”-н цорын ганц “Diamond” спонсороор ХХБ ажиллаа. Арга хэмжээний үндсэн зорилго нь оны ололт амжилтуудаа бататган дүгнэх, хоёр улсын хоорондын бизнесийн орчныг сайжруулж, нийгмийн ач холбогдлыг сурталчилж, өндөр түвшний харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой билээ. /10k\$/



BE LADY FORUM

Жижиг дунд бизнес эрхлэгч, эмэгтэйчүүдийг дэмжих, бизнесийн боломжуудыг танилцуулах, олон улсын байгууллагын сургалт зөвлөгөөг хуваалцаж, хамтран ажиллах боломжтой корпорэйт байгууллагуудтай танилцуулах зорилгоор “Be Lady Forum” зохион байгууллаа.



HAPPY PARK

Улаанбаатар хотын залуусын цагийг зөв боловсон соёлтой, үр өгөөжтэй өнгөрүүлэх хүслийг дэмжих зорилгоор Үндэсний олон нийтийн соёл амралтын хүрээлэнд Happy Park төслийг 1 сар хэрэгжүүлж өглөөний иога, эрүүл мэнд болон боловсролтой холбоотой өдрийн лекцийг хамтрагч байгууллагатай хамтран хийж гүйцэтгэв. Мөн залууст зориулсан урлагийн тоглолтуудыг долоо хоног бүр хийв. Тухайн төслийн барилгын ажлын тохижилт нь дахин боловсруулсан хуванцраар хийгдсэн гэдгээрээ онцлог юм.



ЭМЭГТЭЙ ЭНТЕРПРЕНЕРҮҮДИЙГ ДЭМЖИХ НЬ

Худалдаа Хөгжлийн Банк U.S. Embassy - Ulaanbaatar, Mongolia-тай хамтран эмэгтэй бизнес эрхлэгч нарт зориулсан сонирхолтой арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

- “Эмэгтэй энтерпренерүүдийн академи” хөтөлбөрийн танилцуулга
- Эмэгтэй энтерпренерүүдийн амжилтын түүх
- ХХБ-ны санхүүгийн хөтөлбөрүүд
- Бизнесийн стратеги, түүний ач холбогдлыг таниулах практик сургалт боллоо.

БОДЛОГО

Карьер менежментийн бодлого

Тогтоон барих бодлого

Залгамж халааны бодлого

ХӨТӨЛБӨР

Дэмжих хөтөлбөр

Flexible Mom хөтөлбөр

Дасан зохицох хөтөлбөр

Future leaders удирдах ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх хөтөлбөр

Lady's leadership* нярайн чөлөөнөөс эргэн ажилдаа томилогдон ажиллаж буй эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр

Жендерийн сургагч багш бэлтгэх хөтөлбөр

Ногоон санхүүжилт, тогтвортой хөгжлийн сургагч багш бэлтгэх хөтөлбөр

Дижитал үр чадвар хөгжүүлэх хөтөлбөр

Ментор – 2024 хөтөлбөр

Coaching – 2024 хөтөлбөр

Эрасмус хөтөлбөр



ЗАСАГЛАЛ

- Компанийн засаглал
- Ёс зүй ба комплайнс
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ /хүйсээр/



ЭРСДЭЛ

ICAAP I ILAAP тайланг тогтмол боловсруулан ажиллаж байна.



PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) стандартыг бүрэн хангав.



Компанийн засаглал

Тогтвортой ажиллахад компанийн үр дүнтэй засаглал хамгийн чухал. Энэ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг шийдвэр гаргах үйл явц, байгууллагын урт хугацааны стратегид тусгах боломжийг олгодог. Оновчтой засаглалын тогтолцоо нь ил тод байдал, хариуцлагатай байдал, ёс зүйтэй зан төлөвийг дэмжиж, тогтвортой үйл ажиллагааны бат бөх суурийг бүрдүүлдэг.

Төлөөлөн удирдах зөвлөл

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

Удирдлагын баг

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог. ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

Ажилтнууд

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

**РАНДОЛФ КОППА**

ТУЗ-ын дарга

Тогтвортой хөгжлийн хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2016 он**
 Банкны салбар дахь туршлага: **55+ жил**
 Үндэс угсаа: **АНУ**
 Нас: **83**

ДОЛЖИН ЭРДЭНЭБИЛЭГ

ТУЗ-ын гишүүн

Томилогдсон огноо: **2006 он**
 Банкны салбар дахь туршлага: **30+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **56**

Дамбийжав ХҮРЭЛБААТАР

ТУЗ-ын гишүүн

Томилогдсон огноо: **2020 он**
 Банкны салбар дахь туршлага: **45+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **64**

Дагмид ЯНЖМАА

ТУЗ-ын гишүүн

Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2019 он**
 Банкны салбар дахь туршлага: **45+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **67**

Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

ТУЗ-ын гишүүн

Аудитын хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2023 он**
 Банкны салбар дахь туршлага: **25+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **51**

Авгаан ЭНХМЭНД

ТУЗ-ын гишүүн

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Томилогдсон огноо: **2023 он**
 Банкны салбар дахь туршлага: **25+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **54**

Жалбаа БОЛОРМАА

ТУЗ-ын хараат бус гишүүн

Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2017 он**
 Банкны салбар дахь туршлага: **35+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **61**

Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН

ТУЗ-ын хараат бус гишүүн

Аудитын хорооны дарга, Эрсдэлийн хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2017 он**
 Банкны салбар дахь туршлага: **30 жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **51**

Загдхүү НАРАНТУЯА /2024.11.04 хүртэл/

ТУЗ-ын хараат бус гишүүн

Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Томилогдсон огноо: **2023 он**
 Банкны салбар дахь туршлага: **30+ жил**
 Үндэс угсаа: **Монгол**
 Нас: **59**

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ нь дэргэдээ Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн хороодуудтай бөгөөд тайлант хугацаанд тогтвортой байдлын бодлогыг хангах үүднээс Тогтвортой хөгжлийн хороог байгуулан батлаад байгаа юм. Ингэснээр банк нь ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцсан бүрэн удирдлагын тогтолцоотой болж, ESG зарчимд нийцсэн, хариуцлагатай шийдвэр гаргалтыг дэмжих цогц бүтцийг бүрдүүлээ.



Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо

Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (цаашид "ЦҮНДХ" гэх) нь ХХБ-ны ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ашигтайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий хороо ба ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэрэг эрх үүрэгтэй хороо юм.



Аудитын хороо

Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой ажилладаг.



Эрсдэлийн удирдлагын хороо

Тус хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль журам, зохицуулагч болон олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон зөвлөмж, стандарт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого зэргийн хэрэгжилтийг хянах, чиглэл өгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хороо юм. Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарч хараат бус байдлаар эрсдэлээс хамгаалах, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын хэрэгжилтэнд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг.



Тогтвортой хөгжлийн хороо

Тогтвортой хөгжлийн бодлогоор банкны засаглал, стратеги, зорилго, зорилтыг тодорхойлох, дотоодын болон олон улсын сайн туршлагыг өөрийн төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зарчмууд, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан болно. Байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх замаар банкныхаа үйл ажиллагааны бүхий л түвшинд цогцлооход нягт уялдаа холбоотой ажиллахад тус хорооны үндсэн зорилго оршино.

ТХ-ийн хорооны дарга:

Р.КОППА /ТУЗ-ийн дарга/

ТХ-ийн хорооны гишүүд:

Н.СЭРГЭЛЭН /Олон улсын бизнес, хөгжил хариуцсан ГЗО/

Г.ЧИМИДБАЛДИР /Олон улсын хамтын ажиллагаа болон БОНЗ-ын хариуцсан зөвлөх/

П.ХАЛИУН /Тогтвортой хөгжлийн зөвлөх/

Удирдлагын түвшин дэх мэргэжилтнүүд

Д.ОТГОНБИЛЭГ

Тогтвортой санхүүжилт, БОНЗ-ын бодлого болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд ТҮЗ-өөс тогтвортой хөгжлийн чиглэлээр оновчтой шийдвэр гаргах, цаашдын төлөвлөгөөнд санал зөвлөмж хүргүүлэх, хамтын ажиллагаа зэрэг асуудлыг хариуцаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)

Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны дагаж мөрдөх хууль тогтоомж болон үйл ажиллагааны хүрээний дагуу банканд тулгарч буй асуудлуудыг бодлогын түвшинд шийдвэрлэх, үйл ажиллагааг дэмжих, чиглүүлэх үүргийг гүйцэтгэж буйгаас гадна банкны зорилго, стратегийг баталж, хэрэгжилтэд хяналт тавин зөвлөмж, шийдлээр ханган ажиллаж байна.

П.ХАЛИУН

Тогтвортой хөгжлийн хорооны зөвлөх, EPAM компанид менежментийн зөвлөхөөр ажилладаг бөгөөд тогтвортой байдлын стратеги, үйл ажиллагааны загвар, тайлагналын чиглэлээр ажиллаж ирсэн. Тэрээр өмнө нь World Business Council for Sustainable Development (WBCSD)-д тогтвортой байдлын тайлагнал болон байгаль хамгааллын зах зээлийн санаачилгууд дээр ажиллаж байсан бөгөөд цэвэр технологийн санхүүжилтийн судалгааны туршлагатай.

Тогтвортой хөгжлийн хороо

Тогтвортой хөгжлийн бодлогоор дамжуулан банкны засаглал, стратеги, зорилго, зорилтуудыг тодорхойлох цаашлаад дотоодын болон олон улсын сайн туршлагыг өөрийн төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зэрчмүүд, хамтын ажиллагааг дэмжин ажиллах зорилготой хороо юм.

Г.ЧИМИДБАЛДИР


Олон улсын хамтын ажиллагаа болон БОНЗ-ыг хариуцсан зөвлөхөөр ажиллаж байгаа бөгөөд гадны банк санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татах тэдгээрийг бүтэцжүүлэх, банкны тогтвортой санхүүжилтийг байдлыг дэмжих чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ТҮЗ-ын дэргэдэх ажлын алба (ТҮЗДАА)

Банкны эрх барих дээд нэгжүүд болон холбогдох хороодын тасралтгүй үйл ажиллагааг хангах болон сайн засаглалын олон улсын тэргүүн туршлагыг судлан хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох, ТҮЗ болон Гүйцэтгэх удирдлага, банкны газар, хэлтэс нэгжийн хоорондын харилцааг зохион байгуулж хяналт тавин ажилладаг.

Засаглалын бүтэц

Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлснээр банк нь өөрийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, олон улсын зах зээлээс санхүүжилт татах боломж үүсдэг. Банк нь компанийн засаглалын бүтцэдээ Төлөөлөн удирдах зөвлөл (TV3) болон удирдлагын багийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн хамтын ажиллагаа, харилцааг нарийн тодорхойлсон байдаг. ХХБ нь 1 Захирлын зөвлөл, Гүйцэтгэх захирлын дэргэдэх 13 хороо, 73 газар, хэлтэс, алба, 90 салбар, 13 тооцооны төв, 7 тооцооны касс, 1 дипломат хэсэг, 1 лайт хэсэг, 1 төлөөлөгчийн газар болон 2,261 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХОРООД

- Удирдлагын хороо
- Актив, пассивын хороо
- Зээлийн хороо
- Зээлийн дэд хороо
- Ажилтнуудын зээлийн хороо
- Бүтээгдэхүүн хөгжлийн хороо
- Үйл ажиллагааны эрсдэлийн хороо
- Чанаргүй активын хороо
- Мэдээллийн технологийн хороо
- Тендерийн хороо
- Ёс зүйн хороо
- Жендэрийн хороо
- Цалингийн хороо

Ёс зүй ба комплайнс

ХХБ-ны ESG холбоотой бодлого журмууд

Хүний нөөц	Ёс зүйн дүрэм
	Авлигын эсрэг бодлого
	Хүний нөөцийн бодлого
	Шүгэл үлээх бодлого
	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам
	Жендэрийн эрх тэгш байдлын бодлого
Ханган нийлүүлэлтийн сүлжээ	Тендер шалгаруулалтын журам
	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны заавар

Комплайнсын бодлого

Банкны газар, хэлтэс, нэгжүүдийг үр дүнтэй комплайнсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор 2021 оны 9-р сард банкны комплайнсын бодлогыг олон улсын комплайнсын удирдлагын системийн ISO 37301:2021 Compliance management systems стандартад нийцүүлэн шинэчилж, ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд жил бүр комплайнсын бодлого, журмыг эргэн хянадаг.

Банкны гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилтнууд нь үйл ажиллагаандаа дараах комплайнсын үндсэн зарчмыг баримталж ажиллахаар тусгаж мөн комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн. Үүнд:

- Хууль тогтоомжийн нийцлийн зарчим;
- Шударга байх зарчим;
- Банкны ажил хэргийн нэр хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчим;
- Харилцагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх зарчим;
- Ил тод, тодорхой байх зарчим;
- Аливаа шийдвэр нь баталгаат эх сурвалж, судалгаанд үндэслэсэн байх зарчим;
- Хариуцлага хүлээх зарчим;
- Инновацлаг байх зарчим;
- Бие даасан;
- Хараат бус байх зарчим.

Комплайнсын бодлого, журмын хэрэгжилтийг банкны Комплайнсын хэлтэс хариуцдаг бөгөөд тус үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс хяналт тавин ажиллаж байна. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба (ТУЗДАА)-аар дамжуулан хэрэгжүүлдэг. Ингэхдээ Комплайнсын нэгж нь өөрийн үйл ажиллагаа, хийгдсэн ажил, хэрэгжилт хангасан эсэхийг шалгах, хяналт тавих зорилгоор, улирал тутам ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗДАА-аар дамжуулан үйл ажиллагааны тайланг хүлээн авч, ТУЗ-ийн хурлаараа хэлэлцдэг. Нөгөөтэйгүүр ТУЗ нь өөрийн харьяа, хараат бус нэгж болох Дотоод аудитын газар (ДАГ)-аар дамжуулан банкны үйл ажиллагаанд хяналт тавих замаар хууль тогтоомж, банкны бодлого, журмын хэрэгжилт, ажлын чанарыг үнэлэн дүгнүүлэх, тэдгээрийг нэгтгэсэн тайланг хүлээн авч ажиллаж байна.



Шинэ ажилтны сургалт

Шинээр ажилд орж буй нийт 559 ажилтанд 25 удаагийн давтамжтайгаар орсон байна.



Бататгах сургалт

Нийт 15 удаагийн давтамжтайгаар 619 ажилтанд Бататгах сургалтыг орсон байна.



Тусгайлсан сургалт

Нийт 7 удаагийн давтамжтайгаар дараах газар, хэлтсүүдийн нийт 76 ажилтанд тусгайлсан сургалт орсон.

Дотоод аудит

ХХБ-ны дотоод аудитын бодлогын дагуу дотоод аудитын үйл ажиллагаа нь банкны оролцогч талуудын эрх ашгийн төлөө байх бөгөөд байгууллагын Засаглал, Эрсдэл, Хяналтын үр дүнтэй байдалд бодитой баталгаажуулалт хийж, үнэлж дүгнэх, үйл ажиллагааг нь хэвийн байлгахад чиглэн ажиллахаас гадна цаашид анхаарах, эрсдэлтэй асуудлыг тодорхойлон банкны стратеги, үйл ажиллагаа, санхүү, нийцлийг сайжруулах зөвлөмжийг өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зэрэг зорилго, чиглэлийн дор хэрэгжиж байна.

Дотоод аудитын газар (ДАГ) нь бодлогынхоо хүрээнд банкны засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтад хамаарах тогтвортой байдлын асуудалд зохих хэмжээнд анхаарал хандуулж ажиллаж байна. Тайлант хугацаанд ДАГ нь дараах онцлох аудитын ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Банкны том зээлийн үйл ажиллагаанд "Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх

- заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллаж буй байдал, үүнд харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, эрсдэлийг бууруулах хүрээнд зээлийн шийдвэр гаргахдаа тусгаж ажилласан байдал болон БОНХ-ын үнэлгээ, дүгнэлтээр өгсөн нэмэлт нөхцөлийн биелэлт,
- Банкны тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой судалгаа шинжилгээ, хамтын ажиллагаа, тайлагналт, ногоон болон нийгмийн зээлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа, зээл олгосны дараах хяналт, тайлан мэдээ бэлтгэн хүргэх зэрэг үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хараат бус, бодитой баталгаажуулалт хийн, үнэлэлт, дүгнэлт, өгч ажиллав.
- Мөн тайлант хугацаанд ДАГ нь батлагдсан төлөвлөгөөнийхөө дагуу гүйцэтгэсэн салбар, ТТ-үүдийн эрсдэлд суурилсан аудитаар банкны холбогдох бодлого, журам, заавруудаар БОНХ-ын үнэлгээ хийгдэхээр зохицуулсан зээлүүдийн хувьд тус үнэлгээг хийж, дүгнэлт гарган, зээлийн шийдвэр гаргалтанд тусгаж ажилласан байдал болон БОНХ-ын үнэлгээ, дүгнэлтийн нэмэлт нөхцөлийн хэрэгжилт зэргийг хамруулсан баталгаажуулалтыг хийж ажиллалаа.



Эрсдэлд суурилсан төлөвлөлт

Банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй (ICAAP) болон хөрвөх хөрөнгийн хүрэлцээтэй байдал (LAAP)-ын тооцооллын хүрээнд стресс тестийг тогтмол хийдэг ба олон улсад эсвэл зохицуулагч байгууллагын стресс нөхцөл тодорхойлдог аргачлалтай нийцтэй байх, үзүүлэлтүүд хооронд уялдаа хамааралтай байх гэсэн үндсэн шаардлагын хүрээнд макро эдийн засгийн нөхцөлийг тодорхойлж, түүнд үндэслэн бизнес төлөвлөгөөний хүрээнд банкны зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон хөрвөх чадварын эрсдэлд хэрхэн нөлөөлөхийг тооцдог.

Банк нь "Худалдаа хөгжлийн банкны стресс тестийн бодлого"-ын хүрээнд стресс тестийн шинжилгээг хийж гүйцэтгэн холбогдох үр дүнг хагас жил тутам ҮХ, ЭУХ-нд, жилд нэг удаа ТУЗ-д тайлагнадаг бөгөөд стресс тестийн буцаан шалгалтын үр дүн, стресс тестийн арга, аргачлал, стресс хувилбар болон хариу

арга хэмжээний саналыг боловсруулан хамгийн багадаа жилд нэг удаа ЭУХ-нд танилцуулж ажиллахаар тус бодлогод заасан байдаг. Банк нь урвуу стресс тестийн хувьд банкны нийт болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа зөрчигдөж болзошгүй хүндрэлт нөхцөлийн төсөөлөл, хариу авах арга хэмжээ, хэрэгжихүйц байдлын үнэлгээ болон үр дүнгийн үнэлгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх үеийн ажил, үүргийн дарааллыг нарийвчлан боловсруулан жил бүр Банкны "Тогтворжуулах төлөвлөгөө"-нд тусган Удирдлагын хороо, болон ТУЗ-өөр батлуулдаг. Мөн жил бүр зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэлийн алпетитын лимитийг тогтооходоо Банкны стратегийн зорилго, зорилт, бизнесийн төлөвлөгөөнөөс гадна тодорхой түвшний стресс нөхцөлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр тогтоодог бөгөөд түүнд үндэслэн ирэх жилийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолдог.

Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

ХХБ нь харилцагч болон банкны мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, боловсон хүчин мэргэжилтнүүдээ тасралтгүй хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулан, банканд учирч болох эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлон, тасралтгүй аюулгүй байдлын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын газар (МАБГ) нь кибер аюулгүй байдлыг хангах чиглэл бүрээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн бүтэцтэйгээр банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэн, харилцагчийн мэдээллийг хамгаалж, системийн аюулгүй байдлын үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Бид банкны тасралтгүй үйл ажиллагааг харилцагчид хүргэж буй санхүүгийн болон цахим бүтээгдэхүүн үйлчилгээг найдвартай хүргэх, тэдгээрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах сайжруулах чиглэлээр сүүлийн үеийн технологи нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд Системийн аюулгүй байдал, Техникийн аюулгүй байдал, Мэдээллийн сангийн аюулгүй байдал, NOC, SOC, RED багуудын бүтэц

үйл ажиллагаагаар өдөр тутамд мэдээллийн аюулгүй байдлын сайжруулалт, шинэчлэлт, эмзэг сул байдал илрүүлэх, засварлах чиг үүргээр ажиллаж байна.

Тус стандартаар харилцагчийн карт болон хувийн мэдээллийн нууцлалыг задруулах эрсдэлээс бүрэн хамгаалан ажиллаж байгааг харилцагч нартаа батлан харуулан, итгэлцлийг бий болгож буй ажлын нэг хэсэг юм. ХХБ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитын байгууллагаар мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаа болон банкны дэд бүтэц сүлжээ, сервер систем, тоног төхөөрөмжийн нууцлал аюулгүй байдлыг хангах үүднээс 8 дахь жилдээ төлбөрийн картын аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) стандартын шаардлагуудыг бүрэн хангаж, батламжаа хүлээн авлаа. Энэхүү стандартыг хангаснаар харилцагчийн карт болон хувийн мэдээллийн нууцлалыг задруулах эрсдэлээс хамгаалан ажиллаж байна.



ХАВСРАЛТ

- БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн үзүүлэлтүүд
- SASB индекс
- GRI индекс



БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн үзүүлэлтүүд

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (2022)	Үзүүлэлт (2023)	Үзүүлэлт (2024)	Хэмжих нэгж	Тайлбар
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд							
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм	Тийм	Тийм		"ХХБ-ны 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Climate 30+ Green Forum 2021"-ын үеэр анхлан банк нь 2030 он гэхэд 2 тэрбум ам.долларын санхүүжилтийг харилцагчдадаа олгох, цаашлаад нүүрстөрөгчийн саармаг (Climate neutral) байгууллага болох зорилго дэвшүүлснээ зарласан бөгөөд тус зорилго нь банкны үйл ажиллагааны голлох чиглэл болон өргөжсөөр байна. https://fb.watch/kyZWWGREwV/?mibextid=v7YzmG "
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм	Тийм	Тийм		Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг Банкны нэгдсэн стратегийн төлөвлөгөөнд тусгаж баталсан байдаг. Үүний дагуу газар, нэгжийн жилийн төлөвлөгөөний хүрээнд эдгээр зорилтын хэрэгжилт, хэмжилт, тайлагнал, хяналтын үйл ажиллагаа зохицуулагддаг.
MS2.2			Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Тийм	Тийм	Тийм		Тайлангийн "ЗАСАГЛАЛ" хэсэгт
MS3.1			Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	Үгүй	Тийм		ХХБ нь 2024 оны 2-р сарын 7-ны өдөр ТУЗ-ын дэргэд Тогтвортой хөгжлийн хороогоо байгуулсан ба энэхүү хороо нь тогтвортой хөгжлийн бодлогоор банкны засаглал, стратеги, зорилго, зорилтыг тодорхойлох, дотоод, гадаадын сайн туршлагыг банкны төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зарчмууд, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдаж олон улсын туршлага бүхий зөвлөх, мэргэшсэн, туршлагатай гишүүдтэй, банкныхаа үйл ажиллагааны бүхий л түвшинд сайн засаглалын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх замаар ажиллахаар байгуулагдсан хороо юм. Тус хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд ТУЗ-ын дарга, Олон улсын бизнес хөгжил хариуцсан ГЗО, Олон улсын хамтын ажиллагаа болон ESG хариуцсан зөвлөх мөн Тогтвортой хөгжлийн зөвлөх нар томилогдсон.
MS3.2			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм	Тийм		ХХБ-ны Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн түвшинд тогтвортой санхүүжилт, БОНЗ-ын бодлого, эрсдэл, үйл ажиллагааг чухалчлан анхаарч байгаа ба тогтвортой санхүүжилт, БОНЗ-ын бодлого, эрсдэлийн чиглэлээр олон жилийн туршлага бүхий мэргэшсэн гишүүнийг ТУЗ-ийн бүрэлдэхүүнд сонгон томилсон бөгөөд цаашлаад ХХБ-ны ТУЗ-ийн дарга нь Тогтвортой хөгжлийн хорооны даргаар томилогдсон нь холбогдох асуудлаар мэдрэмжтэй шийдвэр гаргах, зөвлөмж, мэдээ мэдээллээр хангах зэрэг өргөн хүрээгээр банкны бүхий л түвшинд ойлголтыг нэвтрүүлэн чиглүүлэх, удирдах боломжийг бий болгосон.
MS3.3		Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм	Тийм		Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтнаар ХХБ-ны Бизнес, хөгжил хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч ажилладаг ба банкны үйл ажиллагааг ногоон, тогтвортой хөгжилд чиглүүлэхэд анхааран ажилладаг.
